



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

УЛСЫН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГТ  
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД:** БНА-2021/06-04-ШТА-ГА

БАЯНХОНГОР АЙМАГТ ЭРХ ШИЛЖИЖ ИРСЭН  
"УЛСЫН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ"-Т  
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Баянхонгор хот 2021 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор **Б.Мөнхбат**

Утас: 70442584 цахим хуудас: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер **А.Цээням**

Утас: 70442424 цахим хуудас: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)

Ахлах аудитор **М.Алтантуяа**

Утас: 99061861 цахим хуудас: [altantuyam@audit.gov.mn](mailto:altantuyam@audit.gov.mn)

Гэрээт аудитор **Д.Цэцэгмаа**

Утас: 88089024 цахим хуудас: [tsetsegmaad@audit.gmail.com](mailto:tsetsegmaad@audit.gmail.com)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг дараах хаягаар авна уу

---



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2021 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/07

Номгон

**Тайлан баталгаажуулах тухай**

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар тушаалаар батлагдсан “Эрх шилжүүлэх” тухай тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 тоот тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор /М.Алтантуяа/-д үүрэг болгосугай.

Гурав. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

Дөрөв. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /М.Алтантуяа/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /А.Цээням/-д тус тус даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б. МӨНХБАТ

005010066

Баянхонгор аймаг дахь ТАГ-ын дарга,  
Тэргүүлэх аудиторын 2021 оны 4 дүгээр сарын  
29-ний өдрийн А/07 тоот тушаалын хавсралт.

“Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн,  
үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалт.

/ мян.төг/

№	Шийдвэрийн дугаар	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн		Акт
			Зөрчлийн дүн	Албан шаардлага	
А	1	2	3	4	5
1	117	Шинэжинст сумын Соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч “Стандарт тоосго” ХХК-д техник хяналтын зардал 846,7 мянган, зохиогчийн хяналтын зардал 423,3 мянган, нийт 1270,0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн	1270.0		1270.0
2	118	Баян-Овоо сумын 240 хүүхдийн сургуулийн барилгын гүйцэтгэгч “Зүүн шанд” ХХК-д техник хяналтын зардал 167,7 мянган, зохиогчийн хяналтын зардлын 461,3 мянган, нийт 629,0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн	629.0		629.0
3	119	Жинст сумын 240 хүүхдийн Сургуулийн барилгын зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн “Цэсда” ХХК-д хяналтын зардлын 1909,8 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн	1909.8		1909.8
4	120	Жинст сумын 150 хүүхдийн дотуур байрны барилгын гүйцэтгэгч “Жамъян пайтан” ХХК-нийн 2019 онд барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан гүйцэтгээгүй ажлын санхүүжилтийн 113639,8 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэлийг Барилгын хөгжлийн төвөөс хянахдаа магадалшгүй ажлын зардал 24029,4 мянган төгрөгийг хасаж хянасан байхад гүйцэтгэгчид олгосон	24029.4		24029.4
5	120	2020 онд ашиглалтад хүлээн авсан 14 барилга байгууламжийн баримт бичгийн иж бүрдлийг аймгийн ГХБХБГ-ын ирүүлсэн цахим файлаас тулган шалгахад 378 баримт бичиг байхаас 159 буюу 42.1 хувь байгаа нь баримт бичгийн иж бүрдэл хангалтгүй байна.	0	0	
6	121	Жинст сумын 240 суудалтай Соёлын төвийн барилгын нэмэлт ажлын гүйцэтгэгч “Рино Инженеринг” ХХК нь “Гадна хашаа, тохижилт, гэрэлтүүлэг”-ийн ажлуудыг гүйцэтгэснээр ажлын гүйцэтгэл 150,0 сая төгрөгийн санхүүжилт авсан атлаа ажлыг гүйцэтгээгүй байна.	150000.0	150000.0	
7	122	Баянговь сумын Нутгийн захиргааны ордны барилгын ажлын гүйцэтгэгч “Очир заан” ХХК нь 70,7 сая төгрөгийн “Гадна хашаа, тохижилт”-ын нэмэлт ажлыг бүрэн гүйцэтгэснээр гүйцэтгэл гарган баталгаажуулж санхүүжилтийг авсан.	70700.0	70700.0	
8	123	УТХО-аар хэрэгжүүлж 2020 онд ашиглалтад хүлээн авсан 162163,1 мянган төгрөгийн “Тэмүжин театрын их засварын ажил”-ыг орлогод аваагүй, бүртгэлд тусгаагүй	162163.1	162163.1	
<b>Төлбөр зөрчлийн дүн</b>			<b>410701.3</b>	<b>382863.1</b>	<b>27838.2</b>

----oOo-----

## Агуулга

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУХАЙ ТУШААЛ

<b>ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ</b> .....	<b>6</b>
<b>АУДИТЫН ДҮН</b> .....	<b>6</b>
<b>БҮЛЭГ 1. УТХО-ААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХДӨӨ САЛБАРЫН БОДЛОГО, ОРОН НУТАГ, ХЭРЭГЛЭГЧДИЙН ШААРДЛАГАД ҮНДЭСЛЭН ЭРЭМБЭЛЖ, АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНАЛД ҮНДЭСЛЭСЭН БАЙНА.</b> .....	<b>6</b>
А.1 Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд тулгуурлан зохистой төлөвлөгдсөн байна. ....	6
А.2 Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй хэрэгжихгүй байна.....	8
А.3. Тайлант онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санхүүжих дүн нь нийт төсөвт өртгийн 24.0%-иар батлагдсан нь хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилт удааширч үр ашиг буурах эрсдэлтэй байна.....	12
<b>Б. УТХО-ААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АЖИЛЛАХ ОРЧИН САЙЖИРЧ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ НЭМЭГДЭЖ, СУРАГЧДЫН СУРЧ БОЛОВСРОХ ТААТАЙ ОРЧИНГ БҮРДҮҮЛСЭН БАЙНА...</b>	<b>13</b>
Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдаж байгаа ч төсвийн ерөнхийлөн захирагчдаас эрх шилжүүлэхдээ холбогдох журмын заалтыг баримтлаагүй, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс эрх шилжсэн тухай бүр худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.....	13
Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтэд тухай бүр хяналтыг хэрэгжүүлж ажилласнаар ихэнх гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд ажлыг гүйцэтгэсэн байна.....	16
Б.3 Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгчид нь барилга угсралтын явц тухай бүрд нь ил далд ажлын актаар гүйцэтгэлийг баталгаажуулж, санхүүжилтийн гүйцэтгэл гаргах тухай бүр нь гүйцэтгэлийг баталгаажуулан ажиллаж байгаа боловч зарим нэг ажил дээр хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.....	22
Б.4 Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж, шинээр ашиглалтад орсон бүтээн байгуулалтын ажлууд нь үр ашгаа өгч, төрийн үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.....	24
<b>АУДИТЫН ДҮГНЭЛТ</b> .....	<b>28</b>
<b>ҮАГ-т хүргүүлэх санал:</b> .....	<b>30</b>
<b>ЗӨВЛӨМЖ:</b>	<b>31</b>
<b>ХАВСРАЛТ СУДАЛГАА</b>	



## Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОАЖС	Байгал орчин аялал жуулчлалын сайд
БСШУСС	Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсрол сургууль
ЗГ	Засгийн газар
ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗГҮАХХАХТ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТЯ	Зам тээврийн яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУТХҮБ	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СС	Соёлын сайд
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЭХТББ	Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого
УИХ	Улсын их хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХС	Эрчим хүчний сайд

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”;
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл;
- Сангийн сайдын 2018 оны 281 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”;
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд ;
- Баянхонгор аймгийн 2016-2020 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”;
- Баянхонгор аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, түүний хэрэгжилтийн тайлан.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, аудитын менежер А.Цээням аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Алтантуяа, гэрээт аудитор Д.Цэцэгмаа нар хамтран гүйцэтгэв.

Аудитын дэд төлөвлөгөөг 2021 оны 03 дугаар 18-ны өдөр батлуулж, талбарын ажлыг 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдрийн хугацаанд гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 16-ний өдрөөс 29-ний хугацаанд гүйцэтгэж, тайланг Газрын дарга, тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулан 2021 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн дотор Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад хүргүүлэв.

**Хүндрэл бэрхшээл**

Аймаг орон нутагт Ковид цар гарсантай холбогдуулан хатуу хөл хорио тогтоосны улмаас хөдөө сумдад хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг объект дээр нь үзэх боломжгүй нөхцөл, хүндрэл бэрхшээл үүссэн.

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

<b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>	<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоол, “Аудитын сэдэв батлах тухай” Монгол улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/15 дугаар тушаал, “2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2021 оны А/04 дугаар тушаалыг үндэслэн аудит хийв.</p>
<b>Аудитын зорилт</b>	<p>Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын баталсан дэд төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.</p> <p>Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх,</li><li>- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх.</li></ul>
<b>Аудитын хамарсан хүрээ</b>	<p>Аудитад Баянхонгор аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд санхүүжүүлэхээр баталсан 55 төсөл, арга хэмжээнээс эрх шилжин ирсэн 40 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны болон бусад байгууллага, аймгийн Засаг дарга түүний харьяа байгууллага болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.</p>
<b>Аудитын хязгаарлалт</b>	<p>Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хувьд аудитыг гүйцэтгэлээ.</p>
<b>Аудитын арга зүй</b>	<p>Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 300, 3000-3100/ Монгол улсын Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгадагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа болон судалгаа авах, аймгийн Засаг дарга түүний харьяа байгууллагын улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, захиалагч, гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэл, хяналт, санхүүжилтийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийх горимыг хэрэгжүүлж, асуудлын шинжилгээ, арга зүй, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<b>Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:</b>	<p>Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.</p>

**Хүснэгтийн товъёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт № 1	УТХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний чиглэлийг эдийн засаг үндсэн чиглэлтэй харьцуулсан үндэслэсэн судалгаа	8
Хүснэгт № 2	ТАХ-ний төсөвт өртөгт зураг төсвийн үнийн эзлэх хувь	11
Диаграмм №01	УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнээс хамгийн их төсөвтэй 13 ажлын төсөвт өртөг, зураг төсвийн үнийн харьцуулсан судалгаа	10

**Хавсралтын товъёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт №1	Төсөл арга хэмжээний төлөвлөлтийн судалгаа	
Хавсралт №2	Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны судалгаа	
Хавсралт № 3	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн судалгаа	
Хавсралт № 4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаад дуусаагүй, орхигдсон барилга, байгууламжийн судалгаа	



## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль нь 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан бөгөөд уг хуульд 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Баянхонгор аймагт 98292.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 44936.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр 2020 оны төсвийн тухай хуульд тодотгол хийж 17 төсөл арга хэмжээнээс 7922.2 мянган төгрөгийг хасаж нийт 96616.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 төсөл арга хэмжээг 36404.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас Баянхонгор аймагт 40 төсөл, арга хэмжээг 27206.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр эрх шилжүүлснээс 21 нь өмнөх оноос шилжин ирсэн бөгөөд шинээр 19 нь хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ байна.

Аудитад хамрагдах хугацаанд Баянхонгор аймгийн Засаг даргаар Г.Батжаргал 2020 оны 8 дугаар сарын 11 хүртэл, 2020 оны 8 дугаар сарын 12 өдрөөс эхлэн Д.Мөнхсайхан нар ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн зарцуулалтын гүйлгээг нэгдүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн СТСХ-ийн дарга С.Байгалмаа, хоёр дугаар гарын үсгийг төсвийн ерөнхий нягтлан бодогч Ц.Самбууням нар зурж гүйлгээ хийсэн, ажлын гүйцэтгэлийг санхүүжилтийн эрх нээх хүсэлтийг ХБХОТХ-ийн дарга, мэргэжилтэн нар хяналт тавьж ажиллаж байна.

## АУДИТЫН ДҮН

**БҮЛЭГ 1. УТХО-ААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХДӨӨ САЛБАРЫН БОДЛОГО, ОРОН НУТАГ, ХЭРЭГЛЭГЧДИЙН ШААРДЛАГАД ҮНДЭСЛЭН ЭРЭМБЭЛЖ, АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНАЛД ҮНДЭСЛЭСЭН БАЙНА.**

А.1 Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд тулгуурлан зохистой төлөвлөгдсөн байна.

А.1.1. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаартай нийцэж байна.

1. Баянхонгор аймаг эрх шилжүүлсэн шинээр хэрэгжих 19 төсөл, арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаартай нийцэж байна. Шинээр хэрэгжих төсөл арга хэмжээний чиглэлийг хүснэгт №01-аар харуулав.



Хүснэгт №01: УТХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний чиглэлийг эдийн засаг үндсэн чиглэлтэй харьцуулсан үндэслэсэн судалгаа

Төсөл, арга хэмжээний нэр	ТАХ-ний тоо	Монгол улсын эдийн засаг, нийгмийн 2020 оны үндсэн чиглэлийн холбогдох заалт
Сургуулийн барилга, их засвар, дотуур байрны барилга, их засвар	6	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 2, 3.2.3, 3.2.6 дахь заалт
Цэцэрлэгийн барилга, барилгын их засвар	3	МУТХҮБ-2030-ын 2.2.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.2.2.1 дэх заалт
Соёлын төвийн барилгын их засвар	2	ЗГҮАХ-ийн 3.2.47, 3.2.49, 3.2.53, 3.2.54 дэх заалт
Тэмүжин театрын барилгын их засвар	1	ЗГҮАХ-ийн 3.2.47, 3.2.49, 3.2.53, 3.2.54 дэх заалт
Эрүүл мэндийн төвийн барилга, их засвар	3	МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 1, ТЭМТББ-ын 2.4.3.2, 2.4.8.3, ЗГҮАХ-ийн 3.1.6.7, 3.1.15.1, 3.1.15.2 дахь заалт
Эрчим хүчний хүчин чадлыг өргөтгөх, ухаалаг тарифт тоолуурт нэвтрүүлэх	1	ТЭХТББ-ын 4.1.1.6 дахь заалт
Сумын цахилгаан хангамжийг сайжруулах дэд станцын хүчин чадлыг өргөтгөх	1	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 1, ТЭХТББ-ын 3.2.5.3 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.103.1 дэх заалт
Нутгийн захиргааны ордны барилга	1	Үндсэн чиглэл 5.1.21.
Цаг уур өртөөний барилга Баянцагаан	1	Үндсэн чиглэл 4.1.5.

### **Аудитын илрүүлэлт:**

- Баянхонгор аймгийн Баянговь сумын Нутгийн захиргааны ордны барилгын төсөвт өртгийг Монгол улсын 2020 оны төсвийн тухай хуульд 979.5 сая төгрөг, тайлант оны санхүүжилт 179.5 сая төгрөгөөр олгохоор баталсны дагуу Аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн А/460 дугаар захирамжаар "Баянговь сумын Нутгийн ордны барилгыг ашиглалтад орохтой холбогдуулан барилгын зураг төсөвт тусгаагдаагүй зайлшгүй шаардлагатай 75.6 сая төгрөгийн нэмэлт ажлын гэрээг байгуулах" эрх олгожээ. 2020 оны 08 дугаар сарын 19-ны өдөр "Очир заан" ХХК -д нэмэлт ажлын гүйцэтгэл 70.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байхад Монгол улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр дээрх ажлын нийт төсөв өртгийг 890.0 сая төгрөг болгон 89.5 сая төгрөгөөр бууруулан баталсан байгаа нь Монгол улсын 2020 оны төсвийн тухай хуулийг зөрчин батлагдсан төсвийг нийт дүнгээр нь 72.9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байдлаар харагдаж байгаа боловч дээрх шийдвэр нь цаг хугацааны хувьд ажил гүйцэтгэсний дараа гарсантай холбоотой байна.

А.1.2. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ салбарын бодлого, ТЭЗ-ийн саналд үндэслэсэн байна.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтад оруулахаар өмнөх оноос шилжин ирсэн болон шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг Баянхонгор аймгийн Засаг дарга албан бичгээр холбогдох яаманд хүргүүлэн ажилласан байна.

Тухайлбал:

- 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1а/594 тоот албан бичгээр ЗГХЭГ-т
- 2019 оны 1а/597 тоот албан бичгээр БСШУСС-д
- 2019 оны 1а/599 тоот албан бичгээр Сангийн сайдад
- 2019 оны 1а/603 тоот албан бичгээр Эрүүл мэндийн сайдад
- 2019 оны 1а/604 тоот албан бичгээр Эрчим хүчний сайдад



13. Баянхонгор аймагт 2020 онд УТХО-аар нийт 19 төсөл арга хэмжээний 13709.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны тендер зарлах эрх шилжиж ирснээс 13679.0 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 1 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар зохион байгуулжээ.

14. Монгол улсын засгийн газрын 2020 оны 01 дүгээр 22-ны өдрийн 21 дүгээр тогтоолын дагуу БСШУС-ын сайд 2020 оны 02-р сарын 06-ны өдрийн 1а/734 тоот тушаалаар, Эрүүл мэндийн сайд 2020 оны 02-р сарын 14-ний өдрийн А/97 тоот тушаалаар тус тус төсөл арга хэмжээний эрхийг шилжүүлсэн байгаагаас үзэхэд Засгийн газрын эрх шилжүүлсэн шийдвэрийн хугацаанаас 14-22 хоногийн дараа төсвийн ерөнхийлөн захирагчдын шийдвэр гарсан байна.

Харин ЗГХЭГ-аас эрх шилжсэн Баацагаан сумын Засаг даргын тамгын газрын барилга, БОАЖС-аас эрх шилжсэн Баянцагаан сум дахь Цаг уурын өртөөний барилга, ЭХС-аас эрх шилжсэн Баянцагаан сумын цахилгаан хангамжийг сайжруулах дэд станцын хүчин чадлыг өргөтгөх ажил, Баянхонгор сум, 2, 7 дугаар багийн Эрчим хүчний хүчин чадлыг өргөтгөх, ухаалаг тарифт тоолуур нэвтрүүлэх ажлуудын ТЕЗ-ийн шийдвэр ирээгүй, Засгийн газрын тогтоолыг баримталсан байна.

Б.1.2. УТХО-аар хэрэгжих төсөл арга, хэмжээний тендерийг тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

15. Баянхонгор аймагт Улсын төсвөөр хэрэгжих 19 төсөл, арга хэмжээнээс 12 төсөл арга хэмжээний эрхийг 2020 оны 2 дугаар сарын 6-нд, 3 төсөл, арга хэмжээний эрхийг 2020 оны 2 дугаар сарын 14-нд, 4 төсөл арга хэмжээний эрхийг 2020 оны 1-р сард шилжүүлсэн байхад үнэлгээний хороог дунджаар 18 хоногийн дараа байгуулсан байна. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш 14 хоногт багтаан 14 ажлын, 64 хоногт 2 ажлын, 37-39 хоногт 3 ажлын тендерийг тус тус зохион байгуулсан байна.

УТХО-аар хэрэгжих 19 ажлаас Баацагаан сумын сургуулийн барилгын их засварын ажлын тендерээс бусад нь 1-р улиралд багтаж тендер зарлагдаж, эхний хагас жилд гэрээнүүд бүрэн байгуулагджээ.

Тендерийг зарласнаас хойш тендерийг нээх, гэрээ байгуулах хугацаа нь хууль журамд заасан хугацааг мөрдөж ажилласан бөгөөд, үнэлгээний хороо байгуулсан тохиолдолд худалдан авах ажиллагаанд хугацаа алдаагүй байна.

Б.1.3. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу жишиг баримт бичгийг үндэслэн боловсруулсан байна.

16. Тайлант онд УТХО-аар шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог тухай бүр аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан байна. Үнэлгээний хороонд давхардсан тоогоор нийт 95 хүн томилогдсоноос 3 ажлын тендер зарлах болон тендерийг үнэлэх явц 80 хувийн бүрэлдэхүүнтэй, бусад нь гишүүд бүрэн оролцсон байна. Үнэлгээний хорооны гишүүд нь бүгд худалдан авах ажиллагааны АЗ сертификаттай ба журмын дагуу үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй мэдүүлгийг бөглөж гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

**Аудитын илрүүлэлт:**



баригдах 11878.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 барилга байгууламжийн хувьд тайланд онд санхүүжих 2820.2 сая төгрөг буюу 24 хувийн санхүүжилт батлагдсан байна.

Хүснэгт № 4 Санхүүжих дүнг хэрэгжих хугацаатай харьцуулсан судалгаа /сая төг/

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	Санхүүжих хувь
		Эхлэх	Дуусах			
IV.1.31	Засаг даргын Тамгын газрын барилга /Баянхонгор, Баацагаан сум/	2020	2021	1,200.0	372.2	31%
V.1.22	Цаг уурын өртөөний барилга /Баянхонгор, Баянцагаан сум/	2020	2020	98.0	98.0	100%
XII.1.1.194	Дотуур байрын барилга, 75 ор /Баянхонгор, Баянбулаг сум/	2020	2021	1,000.0	300.0	30%
XII.1.1.202	Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Гурванбулаг сум/	2020	2021	1,540.0	50.0	3%
XII.1.1.203	Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Заг сум/	2020	2021	1,540.0	500.0	32%
XII.1.1.231	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, Номгон ахлах сургууль/	2020	2021	3,200.0	500.0	16%
XII.1.1.281	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баянхонгор, Баян-Овоо сум/	2020	2021	1,600.0	500.0	31%
XII.1.1.309	Цэцэрлэгийн өргөтгөл /Баянхонгор, Баян-Өндөр сум/	2020	2021	500.0	200.0	40%
XVII.1.57	Эрүүл мэндийн төвийн барилга /Баянхонгор, Хүрээмарал сум/	2020	2021	1,200.0	300.0	25%
	<b>Нийт</b>			<b>11,878.0</b>	<b>2,820.2</b>	<b>24%</b>

А.3.4. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөөгүй байна.

12. УТХО-аар 2020 онд хэрэгжих төсөл арга хэмжээнд хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээ батлаагүй байна.

**Б. УТХО-ААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АЖИЛЛАХ ОРЧИН САЙЖИРЧ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ НЭМЭГДЭЖ, СУРАГЧДЫН СУРЧ БОЛОВСРОХ ТААТАЙ ОРЧИНГ БҮРДҮҮЛСЭН БАЙНА.**

Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдаж байгаа ч төсвийн ерөнхийлөн захирагчдаас эрх шилжүүлэхдээ холбогдох журмын заалтыг баримтлаагүй, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс эрх шилжсэн тухай бүр худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

Б.1.1. 2020 онд шинээр эхэлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх ажлыг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн боловч журамд заасан хугацаанд шилжүүлсэн байна.



**А.3. Тайлант онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санхүүжих дүн нь нийт төсөвт өртгийн 24.0%-иар батлагдсан нь хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилт удааширч үр ашиг буурах эрсдэлтэй байна.**

А.3.1. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө тайлант онд бүрэн хэрэгжих боломжгүйгээр санхүүжилтийг баталсан байна.

9. УТХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төсөвт өртгийг батлахдаа Магадлал хийгдсэн дүнгээс бага дүнгээр баталж, зөрүүг дараа онд нэмэгдүүлэн баталж дараах барилгын ажлыг гүйцэтгэгч компанитай нэмэгдсэн дүнгээр шууд гэрээ байгуулж хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт № 3 Төсөвт өртөг нэмэгдсэн төсөл арга хэмжээний судалгаа сая төгрөг

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	УИХ-ын 2019 оны УИХ-аар батлагдсан дүн	УИХ-ын 2020 оны УИХ-аар батлагдсан дүн	нэмэгдсэн дүн
1	XII.1.1.216	Сургуулийн барилга, 320 суудал /Баянхонгор, Баянцагаан сум/	3,432.9	4,383.0	950.1
2	XII.1.1.241	Сургуулийн барилга, 960 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, Номундалай сургууль/	6,500.0	9,126.2	2,626.2
3	XII.2.1.62	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Галуут сум/	1,230.0	1,970.0	740.0
4	XII.1.1.210	Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Баянбулаг сум/	1,140.0	1,842.0	702.0
<b>НИЙТ ДҮН</b>			<b>12,302.90</b>	<b>17,321.20</b>	<b>5,018.30</b>

Эх сурвалж: Монгол улсын 2019, 2020 оны Төсвийн тухай хууль

#### **Аудитын илрүүлэлт:**

*Заг сумын 240 суудалтай Соёлын төвийн барилга нь Монгол улсын 2019 оны Төсвийн тухай хуульд нэг хэв маягийн зураг төсвөөр 1230.0 сая төгрөгөөр баригдахаар төсөв батлагдсан боловч барилгын баганаан суурийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр шон суурь болгон өөрчилж шинээр зураг төсөв хийлгэснээр 537.7 сая төгрөгийн төсөв нэмэгдсэн байна.*

А.3.2 Шинээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн мэдээллийг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системд оруулсан байна.

10. Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системд УТХО-аар Баянхонгор аймагт хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний үндсэн мэдээлэл, худалдан авах ажиллагаатай холбоотой худалдан авах ажиллагаанд мөрдөх хугацаа, тухайн төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлт, эрх нээсэн байдлыг оруулсан байна.

А.3.3 Тайлант онд барилгын өргөтгөл, их засварын ажлыг хугацаандаа бүрэн хэрэгжихээр санхүүжилтийг батлуулж, шинээр эхэлж байгаа барилгын ажил он дамжин хэрэгжихээр нийт төсөвт өртгийн 24 хувийг санхүүжүүлэхээр баталсан байна.

11. Баянхонгор аймагт 2020 онд шинээр хэрэгжих эрх шилжсэн УТХО-аар санхүүжигдэх 19 төсөл арга хэмжээнээс барилгын өргөтгөл, их засварын 10 ажилд 1775.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас тайланд онд 1675.0 сая төгрөгөөр санхүүжихээр баталсан нь тайланд онд бүрэн хэрэгжих боломжтой ба харин шинээр



зүлэгжүүлэлтийн ажлыг оруулаагүй зураг төсвийг магадлалын дүгнэлт гарган баталгаажуулж Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан зураг төсөвт тавих шаардлагыг хангаагүйгээс дараах ажлуудад дахин зураг төсөв хийж зураг төсвийн үнэ гарч байгаа нь төсөвт хүндрэл учруулж байна. Тухайлбал:

- Бууцагаан сумын 250 суудалтай Соёлын төвийн барилгын гадна дулаан болон цэвэр усны магистрал шугамыг барилгын зурагт 64 м урттай шугамаар холбох байсныг Бууцагаан сумын нэгдсэн шугам сүлжээнд холбоход 95 м болж өөрчлөгдсөн, барилгын суурийн хөрс геологийн дүгнэлтээс зөрснөөс шалтгаалж барилгын суурыг дайрган хөрсөөр нягтруулсан, барилгын өндөржилтөөс хамааран гадна тохижилтод нэмэлтээр 200м<sup>2</sup> эко хавтан сууриллуулсан зэрэг 218.1 сая төгрөгийн ажлыг Аймгийн Засаг даргын 2020.12.15-ны өдрийн А/817 тоот захирамжийг үндэслэн олгосон.
- Эрдэнэцогт сумын Соёлын төвийн барилгын гадна дулаан, тохижилтын ажилд нэмэлтээр 574.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас зураг төсвийн үнэ 21.5 сая төгрөг,
- Жинст сумын 150 хүүхдийн дотуур байрны барилгын гадна, шугам, сүлжээ, зам талбай, тохижилтын ажилд нэмэлтээр 980.0 сая төгрөгийн төсөв батлагдаж 24.5 сая төгрөгийг зураг төсвийн үнэнд тус тус төлсөн байна.

Иймд зураг төсөв зохиох, магадлалаар баталгаажуулахдаа тухайн төсөл арга хэмжээний зураг төсвийг Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан тавигдах шаардлагыг бүрэн хангуулж иж бүрэн боловсруулж баталгаажуулах, эрх бүхий байгууллагад хүргүүлэх саналыг ҮАГ-т хүргүүлэв.

#### **Аудитын илрүүлэлт:**

Аймгийн ГХБХБГ нь УТХО-аар хэрэгжих төсөл арга хэмжээг гаднах тохижилтын ажил төсөвт өртөгт батлагдаагүй байхад тухайн ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгосон атлаа ашиглалтад орж буй барилгыг “Барилга, байгууламжийн ашиглалтад хүлээх авах комисс” хүлээн авахдаа зураг төсөвт байхгүй гадна орчны тохижилт, хайсжуулалт, гэрэлтүүлгийн ажил хийх зөвлөмж өгч түүний дагуу хөрөнгө оруулалтын тендерийн хэмнэлтээс нэмэлт ажил хийх төсвийг аймгийн Засаг даргын захирамжаар гаргуулан 2020 онд 3 төсөл, арга хэмжээнд 395.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон байна. Тухайлбал:

- Жинст сумын 240 хүний суудалтай Соёлын төвийн барилгын зураг төсөвт гадна хайсжуулалт, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийн ажлууд тусгаагдаагүйгээс аймгийн Засаг даргын 2020.09.15-ны өдрийн А/576 тоот захирамжаар 224.4 сая төгрөгийн,
- Баянговь сумын Нутгийн захиргааны ордны барилгын зураг төсөвт тусгаагдаагүй гадна хайсжуулалт, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийн ажлыг аймгийн Засаг даргын 2020.07.21-ны А/460 тоот захирамжаар 75.6 сая төгрөгийн,
- Баацагаан сумын ЭМТ-ийн их засвар, өргөтгөлийн зураг төсөвт суугдаагүй гадна талбайн тохижилт, хайсжуулалт, гэрэлтүүлгийн ажилд 95.5 сая төгрөгийн нэмэлт ажлын санхүүжилт гарсан байна.

Иймд “Барилга, байгууламжийн ашиглалтад хүлээх авах комисс” барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авахдаа зураг төсвийн дагуу баригдсан объектыг хүлээж авч байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.



олгож байгаа боловч зарим төсөл арга хэмжээ дээр захиалагчийн хяналт болон зохиогчийн хяналтын зардлыг төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч компанид илүү шилжүүлсэн зөрчил илэрлээ.

#### **Аудитын илрүүлэлт:**

- Шинэжинст сумын Соёлын төвийн барилгын ажлын явцад “Баян дизайн” ХХК зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 01/20 тоот дүгнэлт гаргасан. 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн гэрээ дүгнэх маягтаар техник хяналт, захиалагчийн хяналт, нормчлолын сангийн үлдэгдэл санхүүжилтийг суутган авч гүйцэтгэгчид олгох санхүүжилтийг 133.9 сая төгрөг олгохоор шийдвэрлэсэн байхад 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр гүйцэтгэгч “Стандарт тоосго” ХХК-нд 1.3 сая төгрөг илүү шилжүүлснээс техник хяналтын зардал 0.8 сая, зохиогчийн хяналтын зардал 0.4 сая төгрөгийн өглөг үүссэнийг гүйцэтгэгч компаниар нөхөн төлүүлэх,
- Баян-Овоо сумын 240 хүүхдийн сургуулийн барилгын гүйцэтгэгч “Зүүн шанд” ХХК-д хяналтын зардал 0.6 сая төгрөгийг илүү шилжүүлсэн зөрчил илэрснийг гүйцэтгэгч компаниар нөхөн төлүүлэх.
- Жинст сумын 240 хүүхдийн сургуулийн барилгын гүйцэтгэлд “Цэсда” ХХК нь зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн ба тайлант онд зохиогчийн хяналтын зардал 1.9 сая төгрөгийг илүү олгосон зөрчилд нийт 3.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

А.2.3. Зарим төсөл арга хэмжээний зураг төслийг боловсруулах ажил нь хууль батлагдсаны дараа батлагдсан төсөвт багтаан хийж магадлалаар баталгаажуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 29.41 дэх заалт, Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт тайлагналтын журам”-ын 3.2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

8. УТХО-аар хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг магадлалаар баталгаажуулах ажил нь хууль батлагдсанаас хойш хийгдэх, мөн магадлалаар баталгаажсан зураг төсөвт орчны стандартыг хангасан гадна тохижилт, инженерийн шугам сүлжээний ажил дутуу хийгдсэн зэрэг зөрчлүүд давтагдсаар байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

УТХО-аар 2020 онд эрх шилжсэн шинээр хэрэгжих 19 төсөл арга хэмжээнээс 8395.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл арга хэмжээний зураг, төсөв боловсруулах ажлын даалгавар, зураг төсвийн магадлалын ерөнхий дүгнэлт нь 2020 оны Төсвийн тухай хууль батлагдсанаас хойш баталгаажсан байна.

Иймд Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан, иж бүрэн хийгдэж магадлалаар баталгаажуулсан ТЭЗҮ, зураг төсөвтэй, төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

Барилгын хөгжлийн төв нь гадна инженерийн шугам сүлжээний ажил, орчны стандартыг хангахуйц, зайлшгүй тусгах шаардлагатай гадна тохижилт, гэрэлтүүлэг,

<sup>1 1</sup> Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.



1200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн барилгын зураг, төсвийн үнэ нийт төсөвт өртгийн 5.2%-ийг, Баацагаан сумын ЗДТГ-ын барилгын төсөвт өртгийн хэмжээ ижил байхад 3.24%-ийг эзэлж байхад 1767.7 сая төгрөгийн төсөвт өртөг Заг сумын соёлын төвийн зураг төсвийг ДТУА ХХК 11.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн нь хамгийн бага буюу 0.6%-ийг эзэлж байна.

УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнээс хамгийн их төсөвтэй  
13 ажлын төсөвт өртөг, зураг төсвийн үнийн харьцуулсан судалгаа  
Диаграмм №01



**Хүснэгт №2 ТАХ-ний төсөвт өртөгт зураг төсвийн үнийн эзлэх хувь**

Төсөл арга хэмжээний нэр	Зураг төсөл зохиогчийн нэр	Төсөвт өртөг	сая.төгрөг	
			Зураг төсвийн үнэ	ТӨ-т эзлэх хувь
Эрүүл мэндийн төвийн барилга /Баянхонгор, Хүрээмарал сум/	“Цэсда” ХХК	1,200.0	62.5	5.2%
Цэцэрлэгийн барилгын их засвар /Баянхонгор, Жинст сум/	“Цэсда” ХХК	142.0	5.9	4.2 %
Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Баянхонгор, Баянговь сум/	“Цэсда” ХХК	150.0	6.0	4%
Сургуулийн дотуур байрын их засвар /Баянхонгор, Баянговь сум/	“Цэсда” ХХК	100.0	4	4%
Соёлын төвийн өргөтгөл, их засвар /Баянхонгор, Бөмбөгөр сум/	“Цэсда” ХХК	331.0	13.2	4%
Соёлын төв Галуут	Жи Жи Ай	1,970.0	70	3.6 %
Засаг даргын Тамгын газрын барилга /Баянхонгор, Баацагаан сум/	“Цэсда” ХХК	1,200.0	38.9	3.2 %
Дотуур байрын барилга, 75 ор /Баянхонгор, Баянбулаг сум/	“Баян дизайн” ХХК	1,000.0	32.4	3.2 %
Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баянхонгор, Баян-Овоо сум/	“Цэсда” ХХК	1,600.0	47.56	2.9%

7. УТХО-ын санхүүжилтээр баригдаж буй барилга, байгууламжийн барилгын үе шатны ажлуудад зураг төсөл зохиогчоос хяналт хийж зохиогчийн хяналтын зардлыг зохиогчийн хяналт хийсэн тайлан, гүйцэтгэгч компанийн ажлын гүйцэтгэлд үндэслэн



- 2019 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 1а/789 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн боловч албан бичгийн хавсралт судалгааг архивлаж үлдээгүй байна.

А.1.3. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг орон нутаг, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлж холбогдох яамдад хүргүүлсэн байна.

3. Баянхонгор аймгийн ХБХОТХ -т 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад оруулахаар 392826.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 123 төсөл арга хэмжээний санал ирснийг тухайн төсөл арга хэмжээний хэрэгцээ, шаардлага, ТЭЗҮ, зураг төсөв үндэслэл зэргийг эрэмбэлж саналыг холбогдох яамдад хүргүүлснээс 29099.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 төсөл, арга хэмжээнд 13601.2 сая төгрөг батлагдсан байна.

## **А.2 Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй хэрэгжихгүй байна.**

А.2.1. Барилга, байгууламжийн зураг, төсөл зохиох ажлын даалгаврыг салбарын бодлого, хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлага, геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл зэрэгт үндэслэж, боловсруулж байгаа боловч зураг төсвийн үнэ харилцан адилгүй, зарим зураг төсвийн үнэ нийт төсөвт өртгийн 5 - аас дээш хувийг эзэлж байна.

4. УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний архитектур, төлөвлөлтийн даалгаврыг барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн дагуу аймгийн ерөнхий архитектор баталж, зураг төсөв гүйцэтгэгчид хүргүүлсэн байна.

5. Шинээр барих барилга байгууламжийн барилгын ажлын эхлэх зөвшөөрлийг Баянхонгор аймгийн ГХБХБГ нь олгохдоо Барилгын тухай хуулийн 28 дугаар зүйл "Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгох", 28.2-т "Барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтэд дараах баримт бичгийн хавсаргана" гэсэн заалтын дагуу бүрдүүлэх баримт бичгийн иж бүрдлийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### **Аудитын илрүүлэлт:**

*Аудитаар ашиглалтад хүлээн авсан 14 барилга байгууламжийн баримт бичгийн бүрдүүлэлтийг 1 төсөл арга хэмжээнд 27 баримт материал байхаар тооцож Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын ирүүлсэн цахим сангаас тулган шалгахад 378 баримт бичиг байхаас 159 буюу 42.1 хувь байгаа нь баримт бичгийн иж бүрдэл хангалтгүй байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 28.2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.*

*Иймд ГХБХБГ-т улсын комисс хүлээн авсан барилга байгууламжийн болон шинээр барилга эхэлж буй төсөл арга хэмжээний баримт бичгийг нөхөн бүрдүүлж ирүүлэх хугацаатай албан шаардлага хүргүүлэв.*

А.2.2. Барилга, байгууламжийн зураг төсөл зохиогчийн болон захиалагчийн хяналтын зардлыг бодит гүйцэтгэлээс илүү олгосон байна.

6. Аудитаар 2019-2020 онд УТХО-аар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний зураг төсвийн үнийг ажлын нийт төсөвт өртөгтэй харьцуулан судалж үзэхэд зураг төсвийн үнэ нийт төсөвт өртгийн 1.0-5.2%-ийг эзэлж байна. Судалгаанаас үзэхэд засварын ажлын зураг төсвийн үнийн нийт дүнд эзлэх хувь 4.0%, барилга угсралтын ажлынх 1.5-5.2%-ийг эзэлж байна. Үүнээс хамгийн өндөр буюу Цэсда ХХК-ийн гүйцэтгэсэн



- 2020 оны 02 дугаар сарын 27 –ны өдрийн А/55 тоот захирамжаар Бөмбөгөр сумын Соёлын төвийн их засвар, өргөтгөлийн ажлын, 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/60 тоот захирамжаар Тэмүжин театрын барилгын их засварын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүнээр 3 сарын хугацаагаар түр чөлөө авч гадаад явсан ажилтныг томилсон.
- 2020 оны 02 дугаар сарын 20-ны А/50 тоот захирамжаар Баянбулаг сумын дотуур байрны ажлын үнэлгээний хорооны 1 гишүүний А3 сертификатын хүчинтэй хугацаа 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдөр дуусахаар байхад үнэлгээний хорооны гишүүнээр томилж худалдан авах ажиллагаанд оролцуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг боловсруулан дунджаар 5 хоногийн дараа тендерийг зарласан байна. Тендерийн баримт бичгийг тендерийн жишиг баримт бичгийг үндэслэн ерөнхий шаардлагыг тавьж, техникийн тодорхойлолтын дагуу боловсруулсан байна.

Б.1.4. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, худалдан авах ажиллагааны бүх үйл явцыг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

17.Тендер шалгаруулалтын холбоотой мэдээлэл, тендерт оролцоход шаардлагатай бүрдүүлэх материал, урилгыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй мэдээлж, Тендер шалгаруулалтыг зарлахдаа тендерийн урилга, холбогдох баримтыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим сайтаар болон “Монголын үнэн” сонин хэвлэлээр олон нийтэд нээлттэй мэдээлж, тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулан, оролцогч болон үнэлгээний хорооны гишүүдийг байлцуулан тодорхой, товлосон цагт нээж байгаа нь гүйцэтгэгчийг ил, тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган Сангийн сайдын 2013 оны 84-р тушаалаар батлагдсан “Цахим сүлжээнд тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”-ын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.

18. Төсөв нэмэгдсэн төсөл арга хэмжээг тендерийн хэмнэлтээс санхүүжүүлж буй ажлын нэмэгдсэн төсөв нь нийт төсөвт өртгийн 15 хувиас хэтрээгүй тул ТБОНӨХБАУХАТ хуулийн дагуу аймгийн Засаг даргын захирамжаар шууд гэрээ байгуулсан байна.

Б.1.5. ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь төлөвлөж, тайлагнасан байна.

19. Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний тайланг Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, журам”-ын дагуу батлагдсан маягтаар болон бичмэл тайлангаар хагас бүтэн жилээр гарган Сангийн яаманд хүргүүлж ажилласан байна.

20. Аймгийн ТЕЗ-чийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр дээрх тушаалаар батлагдсан маягтын дагуу бэлтгэж баталсан бөгөөд тайланг хугацаанд УИХ-ын ээлжит бус чуулганаар 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн төсвийн тодотголын дараа буюу 2020 оны 09 дүгээр



сарын 24-ний өдөр буюу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж баталсан нь Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалын 1-р хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх тайлагнах журам”-ын 2.13.Захиалагч хуулийн 46.3-т<sup>2</sup> заасны дагуу” гэснийг хэрэгжүүлж ажилласан байна. Худалдан авах ажиллагааны тайлан, үр дүнгийн талаарх мэдээллийг тухай бүр “tender.gov.mn” сайтад байршуулсан байна.

## **Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтэд тухай бүр хяналтыг хэрэгжүүлж ажилласнаар ихэнх гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд ажлыг гүйцэтгэсэн байна.**

Б.2.1. Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэсэн боловч ажлын чанар шаардлага хангахгүй байх зөрчил арилахгүй давтагдан гарсаар байна.

21. Тайлант онд хөрөнгө оруулалтын 40 төсөл арга хэмжээнээс 19 нь гэрээний сунгалт, болон гэрээнд өөрчлөлт оруулсан байна.

22. Баянхонгор аймагт 2020 онд эрх шилжин ирсэн 40 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс 26 нь бүрэн хэрэгжсэн, 4 төсөл арга хэмжээ нь 90-95 хувьтай, 1 төсөл арга хэмжээ -81 хувь, бусад төсөл арга хэмжээ нь 2020 онд шинээр баригдаж эхэлж барилга байгууламж байна. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг улсын комиссын актаар баталгаажсан байна. /Хавсралт судалгаа 3/

23. Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын 40 төсөл арга хэмжээнээс 14 нь дараа онд шилжиж байгаагийн хуулийн дагуу 2020 онд дуусах 4 төсөл, арга хэмжээ нь гэрээний сунгалт хийж гүйцэтгэл 90-95 хувь, Гурванбулаг сумын 160 хүүхдийн сургуулийн 1540.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тайланд онд 50.0 сая төгрөгийн санхүүжих байсан барилгын ажил эхлээгүй байна. /Хавсралт судалгаа 3/

### **Аудитын илрүүлэлт:**

*Аудитаар 2020 онд ашиглалтад хүлээн авсан 26 төсөл арга хэмжээний чанар байдлыг ашиглагч байгууллагаас ирүүлсэн саналыг нэгтгэн үзэхэд 11 төсөл арга хэмжээ нь ашиглалтын явцад чанарын шаардлага хангахгүй байна. Тухайлбал:*

Хүснэгт 5 2020 онд УТХО-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний талаар ашиглагч байгууллагаас ирүүлсэн саналыг нэгтгэл

№	Төсөл арга хэмжээний нэр	Ашиглагч байгууллагын санал
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Баянхонгор, Баянговь сум/ Гүйцэтгэгч “Очир заан” ХХК	Барилгын зарим цонхны шил хагарсан, тагтны амрах тавцанд плита наах, гадна, дотор камеруудыг ашиглалтад оруулах, галын аюулгүй схемийн зураг хийлгэх, цахилгааны шийтэд хаяг, схем байршуулах.
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга	Өвлийн улиралд цэвэр бохир усны гадна шугам сүлжээ хөлдсөн, цонхоор дулаан алдалт ихтэй байсан зэрэг доголдол үүссэнийг тухай үед нь гүйцэтгэгч байгууллагад хандаж засварлуулсан

<sup>2</sup> эрх шилжүүлэх тохиолдолд төсөв баглагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх



	/Баянхонгор, Баянхонгор сум/ Гүйцэтгэгч "Эх бүрдэн" ХХК		боловч одоогийн байдлаар бүх өрөөний хана цууралт өгсөн, зарим өрөөний цонх хагарсан байдалтай байна.
3	Дотуур байрын барилга /Баянхонгор, Жинст сум/ Гүйцэтгэгч "Жамьян пайтан" ХХК		Ашиглалтад орсноос хойш дээврээс ус гоожиж гүйцэтгэгч байгууллагад хандаж засварлуулсан. 2021.03.14-ний шуурганаар дээврийн 10м2 талбайн хар цаас хуурч унасан, өрөө танхимд суулт өгч хана блок хоорондын залгаагаар хагарсан, өрөөнүүдэд агааржуулалтын хоолой байхгүйгээс бүгчим зэргийг засварлуулах шаардлагатай.
4	Бага сургуулийн барилга, 240 суудал /Баянхонгор, Баян-Овоо сум/ Гүйцэтгэгч "Зүүн шанд" ХХК		2020 онд ашиглалтад орсон боловч хананд цууралт үүссэн, ангиудын цонх хагарсан, сангийн шугам шаардлага хангахгүйгээс шалан доогуур удаа дараа ус алдсан, 1 давхрын 3 ангийн цахилгааны монтажид гал гарч цахилгааны утас шатсан, хаалга, цонхны хамгаалалт резин хийгээгүйгээс тоосжилт ихтэй байдаг.
5	Сургуулийн барилга, 240 суудал /Баянхонгор, Жинст сум/ Гүйцэтгэгч "Эх бүрдэн" ХХК		Спорт заал, урлагийн заалны дээврээс хур тунадас орсон үед хур тунадас орсон үед ус гоождог, их хэмжээний шороо тоос ордог тул дээврийг солиулах, 2021.03.14-ний шуурганаар 3 давхрын гадна фасад 12м2 орчим хуурч унасан засуулах шаардлагатай. Аудитын явцад гүйцэтгэгчтэй холбогдон ашиглагчийн ирүүлсэн саналыг талаар тодруулахад тус сургуулийн барилгыг зургийн дагуу гүйцэтгэсэн. Спорт заалны дээврээс ус гоождог зөрчил нь барилгын зурагт заалны барилгыг П хэлбэртэй барилгын голд байрлуулж, усны хаялгыг 2 талын хана руу гаргасан зургийн алдаатай холбоотой. Зурагт зохиогчоос өөрчлөлт оруулж ирсэн тохиолдолд баталгаат хугацаанд зөрчлийг арилгах боломжтой, бусад зөрчлийн хувьд ашиглагч байгууллагатай холбогдон засвар үйлчилгээг хийж ирсэн гэсэн тайлбарыг 2021.04.27 өдрийн 41 тоот албан бичгээр ирүүлсэн байна
6	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Жинст сум/ Гүйцэтгэгч "Рино инженеринг" ХХК		Гадна гэрэлтүүлэг, сүүдрэвч хийлгэх, халаалтын орохын труба томсгох, тусгаарлах вакум хаалга хийлгэх шаардлагатай байгаа
7	Соёлын төвийн барилга, 250 суудал /Баянхонгор, Бууцагаан сум/ Гүйцэтгэгч "Рок пойнт групп" ХХК		Дээврийн хөндийг дагаж урлаг заалны дээврээс дусаал гоожиж байгаа, зарим өрөөний цонхны завсар ихтэй байгаагийн улмаас, дулаан алдагдал болон хаврын салхи шуурганд шороо тоос их орж байна.
8	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Баянхонгор, Өлзийт сум/ Гүйцэтгэгч "Хүрэн жинсны овоо" ХХК		Агааржуулалтын хоолойтой холбоотой дулаан алдалт их, шороо тоос их ордог дуу чимээ ихтэй, цэврийн шугам задарч ус алдсанаас 1 давхрын таазанд нуралт үүссэн, барилгын хананд цууралт үүссэн, дотор хананы шавар нурсан, дотор 00 ашиглах боломжгүй бохир үнэртдэг, хаалганы црожнууд муу гараар онгойдог түгжээ нь буруу харж байрласан, хуучин барилгын засварын шал стандарт бусаас халтирдаг, дотор өрөөнүүдэд сольсон шинэ хаалганууд нь эвдэрч эхэлсэн, өрөөнүүдийн цонхыг бүрэн солиогүй.
9	Цэцэрлэгийн өргөтгөл /Баянхонгор, Баян-Өндөр сум/ Гүйцэтгэгч "Бридж констракшн" ХХК		2021.03.14-ний шуурганаар барилгын дээврийн хүрээлсэн төмөр нэлэнхийдээ хуурч унасан тул шуудайнд шороо хийж тойруулж тавьсан, гадна талын үерийн далангийн хэсэг дутуу хийгдсэн, явган хүний замын хэсэг, үүдний тамбар, шатыг гөлгөр плитагаар хийсэн, 00-ын плитаг зориулалтын бус цавуугаар нааснаас нурсан, хулдаас хуурсан, дотор хөлийн хэсгийн хана цуурсан ажлуудын талаар гүйцэтгэгч компанид хандсан ба дулааны улирал эхлэхээр засварлаж өгөхөөр тохирсон байгаа.



10	Цэцэрлэгийн барилгын их засвар /Баянхонгор, Жинст сум/ Гүйцэтгэгч "Зүүн шанд" ХХК	Ашиглалтад орсноос хойш сар хүрэхгүй хугацаанд цонх, хаалганы түгжээ, шалны залгаас эвдэрч амлагааны шавар хагарсан, дулаан алдалт ихтэй, цонхны төмөр хаяавч ховхорсон, гал тогооны агааржуулагч ажиллахгүй зэрэг ажлуудыг засварлуулах шаардлагатай
11	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Баянхонгор, Баян-Өндөр сум/ Гүйцэтгэгч "Хонгор констракшн" ХХК	Ашиглалтад орсноос хойш дараах дутагдал доголдол гарсан. Үүнд: Өрөөнүүдийн тааз маш муу, эмийн сангийн зориулалтын өрөөний тааз нурж унасан, халаалтын шугам буруу тавигдсанаас халаалт муу, эмчийн байрны паарнаас байнга ус гоождог, муу усны шугам хөлдөж битүүрсэн, бохир ус соролт маш муу, эмийн сангийн зориулалтаар баригдсан өрөө нь зураглалын дагуу баригдаагүй маш жижиг, агуулах байхгүй.

Дээрх зөрчлүүдийн шалтгааныг Мэргэжлийн хяналтын газраар тогтоолгон дүгнэлт гаргаж буруутай этгээдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцуулах, дутуу болон чанаргүй ажлын хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг дахин хэрэгжүүлэх зөвлөмжүүдийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

24. 2020 онд ашиглалтад оруулсан 12 объектын чанарын баталгааны 1280.5 сая төгрөгийг аймгийн Төрийн сан дахь барьцаа хөрөнгө оруулалтын 100030051350 тоот дансанд байршуулсан байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

*Баянговь сумын Нутгийн захиргааны ордны барилгын гүйцэтгэгч "Очир Заан" ХХК-иас 48.2 сая төгрөгийн чанарын баталгааны мөнгө байршуулсан боловч гүйцэтгэгч байгууллагын хүсэлт ирүүлсний дагуу 2020.12.24-ны өдөр 20.0 сая төгрөгийг "Очир заан" ХХК-д буцаан олгосон нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43 дугаар зүйлийн 43.6. дахь заалтыг зөрчсөн тул цаашид барьцаа дансны хөрөнгийг хуулийн дагуу хугацаа болоогүй байхад гүйцэтгэгч байгууллагад олгодог байдлыг таслан зогсоох зөвлөв.*

Б.2.2. Захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг хэрэгжүүлсэн талаарх тайланг гүйцэтгэгч тухай бүр гаргаж ирүүлсэн боловч зарим арга хэмжээний хувьд хяналтын ажлын үр дүн гарахгүй байна.

25. Баянхонгор аймгийн хэмжээнд 2020 оны байдлаар эрх шилжсэн болон эрх шилжээгүй нийт 96226.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 53 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд аймгийн ГХБХБГ нь Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан гэрээний дагуу хамтран захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд хяналт хийж илэрсэн зөрчлийг барилга байгууламжийн хяналтын дэвтэрт тухай бүрд нь тусгаж зөрчлийг арилгуулдаг бөгөөд явцын хяналтаар илэрсэн зөрчилд өгсөн үүрэг даалгавраас хэсэгчлэн дурдвал:

Хүснэгт№6 Хяналтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

<b>Хүрээмарал сумын 240 хүний суудалтай соёлын төвийн барилга</b>	<b>Жинст сумын 240 хүүхдийн барилга</b>	<b>Бууцагаан сумын 250 хүний соёлын төв</b>
---	---	---



<p>- Тэнхлэг зөрсөн багануудыг хэмжилт хийлгэн зохиогчоос зураг гаргуулан зөвшөөрлийн дагуу ажлаа үргэлжлүүлэх.</p> <p>- МХГазраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах.</p> <p>- Бетоны шинжилгээг хугацаанд өгч шинжлүүлэх.</p> <p>- Баганын арматурыг таргалуулах шийдвэр гарсан тохиолдолд тухай бүрд нь фото зургаар баримтжуулан мэдэгдэж байх.</p> <p>- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар өгч баталгаажуулан ажиллах, санамж байршуулах.</p> <p>Дээрх зөвлөмжийн дагуу зураг төсвийн "Цэсда" ХХК-иас зурагт өөрчлөлт оруулан зургийн дагуу хийж гүйцэтгэсэн тайланг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.</p>	<p>- Шилэн хийцлэлийн доод талын өрлөгийг дахин нурааж өрөх. Жижиг хагарсан блокыг солих.</p> <p>- Барилгын консулуудын дээр налуу дээвэр хийж ус урсах чөлөөт уналттай болгох.</p> <p>- Спорт заал, соёлын заал, сургуулийн барилгын дээврүүдийн ус урсалтыг дахин зохиогчтой зөвшилцөж шийдэл гаргах.</p> <p>- Шилэн хийцлэлүүдийн бэхэлгээг сайтар шалгаж шаардлагатай газар нь хүчитгэх.</p> <p><i>Дээрх зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэсэн.</i></p>	<p>- Зураг төслөөр 1-р давхрын коридорын ханыг хуванцар хавтан наахаар төлөвлөсөн нь хэрэглээний хувьд зохимжгүй байна.</p> <p>- Төв хаалганы пандуст 70, 90 см өндөртэй 2 давхар бариул хийж өгөх.</p> <p>- 00 өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоноглол хийх.</p> <p>- Зурагт тусгасан бохирын шингээх цооног нь байгаль орчин болон эрүүл ахуйн хувьд зөвшөөрөгдөхгүй тул соруулдаг цооног болгон өөрчлөх. /зохиогчоос зөвшөөрөл авах/</p> <p>Дээрх зөвлөмжийн дагуу "Осиб-3Т" ХХК-ас зурагт өөрчлөлт оруулан гүйцэтгэсэн.</p>
---	---	--

26. Зохиогчийн хяналтыг захиалагчтай хийсэн гэрээний үндсэн дээр зураг төсөв зохиогч хэрэгжүүлж байгаа бөгөөд хэрэгжилт дуусаж хүлээн авсан барилгын хувьд зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт гаргаж захиалагчид ирүүлдэг бөгөөд, хэрэгжиж дуусаагүй барилгын хувьд хяналтын тайланг явцын дундуур зохиогчийн хяналтыг хэрэгжүүлж байна.

Зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлтэд барилга явцад илэрсэн зөрчлийг тухай бүрд засаж, залруулж байсныг тусгасан байна.

Тухайлбал: Жинст сумын ЭМТ-ийн барилгын явцад зохиогчийн хийсэн дүгнэлт дээр

- Барилгын парапет болон шилэн фасадын дээрх консул зураг дээр цутгалтаар байсан хэдий ч өрлөгөөр гүйцэтгэсэн. Хийсэн өрлөг нь түгжээ өрлөг байхгүй байсан тул буулгуулж дахин цутгалт хийлгүүлсэн.
- Ашиглагч байгууллага эмнэлгийн зориулалттай барилгад дураараа өрөө тасалгаанд хаалга гарган өрөөний зориулалтыг өөрчилсөн тус МХГ-ын эрүүл ахуйн улсын байцаагчтай зөвшилцөн шийдвэрлэх шаардлагатай гэж өгсний дагуу үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Захиалагч нь барилга угсралтын ажлын үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажилласны үр дүнд зөрчлүүдийг тухай бүрд нь засаж, залруулж байгаа боловч 2020 онд ашиглалтад орсон барилгын чанар байдалд ашиглагч байгууллагаас ирүүлсэн санал гомдлоос харахад барилгын зарим ажил дутуу, цонхны битүүмж муугаас шороо тоос орох, дулаан алдагдалтай, дээврээс дусаал гоождог, сангийн холболт чанаргүй хийгдсэнээс паарнаас ус алдсан нийтлэг зөрчлүүд гарсан байна.

Б.2.3. Хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага хүлээн авч НББ-д тусгасан байна.

27. Монгол улсын 2020 оны хөрөнгө оруулалтаар БШУЯ-аас 2020 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 12/3158 албан бичгийн дагуу олгосон тавилга, тоног төхөөрөмжийн жагсаалтыг тулган шалгахад Баянхонгор аймгийн сургууль, цэцэрлэг



боловсролын 109 байгууллагад 748.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөс “Номун далай” сургуульд нийлүүлэгдсэн 0.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж ирээгүй харин бусад хөрөнгийг ашиглагч байгууллагууд хүлээн авч үндсэн хөрөнгөнд орлогод авч бүртгэсэн байна.

Мөн БШУЯ-аас Баянхонгор аймагт ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл зүйн лаборатори кабинетын тоног төхөөрөмж худалдан авах 55.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан боловч эрх шилжээгүйгээс аймагт худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй байна. Дээрх арга хэмжээний дэлгэрэнгүй судалгааг гаргаж аудитын явцад ҮАГ-т хүргүүлэв.

Б.2.4. Гүйцэтгэгчид олгосон төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэл гаргасан тайлан, түүнийг баталгаажуулсан баримтаас үзэхэд зориулалтын дагуу олгосон байна.

28. УТХО-аар 2020 онд хэрэгжих төсөл арга хэмжээний санхүүжилтэд БОАЖС-аас 93.9 сая, БШУС-аас 15363.3 сая, ЗГХЭГ-аас 535.1 сая, СС-аас 6171.1 сая, БТСУХ-ноос 2000.0 сая, ХХҮЕГ-аас 236.0 сая, ЭМС-аас 1559.9 сая, ЭХС-аас 388.7 сая, нийт 26348.1 сая төгрөгийн санхүүжилтийн эрх нээгдэж, төсөл арга хэмжээний гүйцэтгэгч байгууллагууд Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт тайлагналын журамд заасны дагуу батлагдсан маягтаар гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг гарган захиалагчаар хянуулж санхүүжилтийг авсан байна.

Хүснэгт №7 Гүйцэтгэгчид олгосон санхүүжилт

сая.төг

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээний үнийн дүн	Нийт санхүүжилт	2020 онд олгосон санхүүжилт
А		2	3	4	5
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Баянхонгор, Баянговь сум/	Очир Заан ХХК	964.24	962.95	162.95
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	"Эх бүрдэн" ХХК	1,016.02	1,016.02	236.02
3	Дотуур байрын барилга /Баянхонгор, Жинст сум/	Жамьян пайтан ХХК	2,400.89	2,380.16	963.41
4	Бага сургуулийн барилга, 240 суудал /Баянхонгор, Баян-Овоо сум/	"Зүүншанд" ХХК	2,069.94	2,069.94	1,069.94
5	Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Баянбулаг сум/	Шинэ өлгийн зам ХХК	1,832.31	1,722.00	1,322.00
6	Сургуулийн барилга, 240 суудал /Баянхонгор, Жинст сум/	Эх бүрдэн ХХК	2,396.36	2,378.06	1,399.98
7	Сургуулийн барилга, 320 суудал /Баянхонгор, Баянцагаан сум/	Навтгар хайрхан ХХК	4,214.37	1,433.08	632.85
8	Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/	Хөх бүрдний эх ХХК	4,995.40	4,664.51	577.88
9	Сургуулийн барилга, 1200 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, Номундалай сургууль/	Хаш гоёо ХХК	9,258.51	8,758.52	6,258.53



10	Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/	"Жамъян пайтан" ХХК	1,266.80	1,195.27	695.27
11	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Жинст сум/	Рино инженеринг ХХК	1,720.22	1,690.58	395.05
12	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Галуут сум/	Жи Жи Ай ХХК	1,970.00	1,871.28	1,002.40
13	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Заг сум/	Алегротровер ХХК	1,668.05	1,541.93	898.70
14	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Хүрээмарал сум/	"Ганмөнхжин" ХХК	1,669.63	1,349.60	949.60
15	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Шинэжинст сум/	"Стандарт тоосго" ХХК	1,198.90	1,198.90	198.90
16	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	Хаш гоёо ХХК	1,767.25	1,733.26	868.60
17	Соёлын төвийн барилга, 250 суудал /Баянхонгор, Бууцагаан сум/	Рок пейнт групп ХХК	1,896.44	1,835.18	1,435.18
18	Усан бассейн, спорт цогцолборын барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	"РМВ" ХХК	8,730.55	4,020.00	2,000.00
19	Эрүүл мэндийн төвийн их засвар, өргөтгөл /Баянхонгор, Баацагаан сум/	Өлзийтийн хийморь өөдөө ХХК	821.98	821.94	121.95
20	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Баянхонгор, Жинст сум/	"Шинэ Өлгийн зам" ХХК	756.91	756.27	356.27
21	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Баянхонгор, Өлзийт сум/	"Хүрэн жинсны овоо" ХХК	781.91	768.67	368.67
22	Засаг даргын Тамгын газрын барилга /Баянхонгор, Баацагаан сум/	Бианконэроконстракшн ХХК	1,127.76	372.2	372.20
23	Цаг уурын өртөөний барилга /Баянхонгор, Баянцагаан сум/	Энх баялаг констракшн ХХК	95.35	93.97	93.97
24	Дотуур байрын барилга, 75 ор /Баянхонгор, Баянбулаг сум/	Стандарт тоосго ХХК	944.34	300	300.00
25	Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Гурванбулаг сум/	Стандарт тоосго ХХК	-	-	-
26	Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Заг сум/	Энх баялаг констракшн ХХК	1,519.17	500	500.00
27	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, Номгон ахлах сургууль/	Эх бүрдэн ХХК	3,101.40	500	500.00
28	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баянхонгор, Баян-Овоо сум/	Зүүн шанд ХХК	1,589.80	500	500.00
29	Цэцэрлэгийн өргөтгөл /Баянхонгор, Баян-Өндөр сум/	Бридж констракшн ХХК	453.59	200	200.00
30	Сургуулийн барилгын их засвар /Баянхонгор, Баацагаан сум/	Бүдума ХХК	202.67	202.67	202.67
31	Сургуулийн дотуур байрын их засвар /Баянхонгор, Баянговь сум/	Сүндэр констракшн ХХК	98.89	98.89	98.89
32	Цэцэрлэгийн барилгын их засвар /Баянхонгор, Жинст сум/	Бэнжцэс ХХК	141.9	141.9	141.90
33	Соёлын төвийн өргөтгөл, их засвар /Баянхонгор, Бөмбөгөр сум/	Эм ти эм жи ХХК	314.56	231	231.00
34	Соёлын төвийн барилгын засвар /Баянхонгор, Баацагаан сум/	Эх бүрдэн ХХК	29.48	29.48	29.48
35	Хүүхдийн "Тэмүүжин" театрын барилгын их засвар /Баянхонгор, Баянхонгор сум/	Нью бест хаус ХХК	162.16	162.16	162.16
36	Сумын цахилгаан хангамжийг сайжруулах дэд станцын хүчин чадлыг өргөтгөл /Баянхонгор, Баянцагаан сум/	Түнтгэр нөөлөгт инженеринг ХХК	103.82	103.82	103.82



37	Эрчим хүчний хүчин чадлыг өргөтгөх, ухаалаг тарифт тоолуур нэвтрүүлэх /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7 дугаар баг/	Түнтгэр нөөлөгт инженеринг ХХК	284.91	284.91	284.91
38	Эрүүл мэндийн төвийн барилга /Баянхонгор, Хүрээмарал сум/	Зураан даваа ХХК	1,168.06	300	300.00
39	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Баянхонгор, Баянговь сум/	Тэнгэрийн уул ХХК	149.59	149.59	149.59
40	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Баянхонгор, Баян-Өндөр сум/	Хонгор констракшн ХХК	263.37	263.37	263.37
		-	65,147.50	48,602.10	26,348.12

**Б.3 Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгчид нь барилга угсралтын явц тухай бүрд нь ил далд ажлын актаар гүйцэтгэлийг баталгаажуулж, санхүүжилтийн гүйцэтгэл гаргах тухай бүр нь гүйцэтгэлийг баталгаажуулан ажиллаж байгаа боловч зарим нэг ажил дээр хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.**

Б.3.1. Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналт бүрэн, үр дүнтэй хэрэгжихгүй байна.

29. 2020 онд УТХО-аар БСШУСС, ЭМС, ХНХС-ын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд Барилгын хөгжлийн төвөөс хяналт тавихаар 2020.03.27-ны өдөр "Барилгын захиалагчийн хяналт хэрэгжүүлэх гэрээ", аймгийн ГХБХБГ-тай 2020.04.14-ны өдрийн 2020/29 тоот "Улсын болон орон нутгийн төсвөөс барилга, байгууламжид хяналт тавих, хяналтыг зардлыг зарцуулах, хамтран ажиллах гэрээ" хамтран ажиллах гэрээг аймгийн Засаг даргатай байгуулж үе шатны хяналтыг хэрэгжүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласны үндсэн дээр техник хяналтын зардлыг Барилга хөгжлийн төв болон аймгийн ГХБХБГ-т шилжүүлэн өгсөн байна. Гэвч дээрх гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж гэрээг дүгнээгүй байна.

30. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгчид нь барилга угсралтын явц тухай бүрд нь ил далд ажлын актаар гүйцэтгэлийг баталгаажуулж, санхүүжилтийн гүйцэтгэл гаргах тухай бүр нь гүйцэтгэлийг баталгаажуулан ажиллаж байгаа боловч зарим нэг ажил дээр хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

#### **Аудитын илрүүлэлт:**

*Жинст сумын 240 суудалтай Соёлын төвийн барилгын нэмэлт ажил "Гадна хашаа, тохижилт, гэрэлтүүлэг" 224.4 сая төгрөгийн гэрээг "Рино Инженеринг" ХХК -тай байгуулж нэмэлт ажлыг 2020.10.12-ны өдрийн "Барилгын ажлын явцад хийсэн зохиогчийн хяналт хийсэн тайлангаар гэрэлтүүлэг хийгдээгүй гэж тайланд дурдсан байхад 2020.10.13-ны өдрийн барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтэд "нэмэлт ажилд гадна хашаа, гоёлын гэрэлтүүлэг, ногоон байгууламжийн ажлууд багтсан бөгөөд ажлуудыг гүйцэтгэсэн" гэж комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулснаар гүйцэтгээгүй ажилд 150.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.*

*Баянговь сумын Нутгийн захиргааны ордны "Очир заан" ХХК-ийн гүйцэтгэх нэмэлт ажил "Гадна хашаа, тохижилтын ажил"-ын 2020.08.02 өдрийн 01/2020 тоот барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтэд "Энэхүү тохижилтын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв." гэж дүгнэж комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулснаас гүйцэтгээгүй ажилд 70.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.*



Иймд дутуу гүйцэтгэсэн ажлыг гүйцэтгэгч компаниар хийлгүүлж зөрчлийг арилгах албан шаардлага, ажлыг дутуу гүйцэтгэсэн байхад бүрэн гүйцэтгэсэн дүгнэлт гаргаж хүлээн авсан комиссын гишүүдэд хариуцлага тооцох саналыг тус тус аймгийн Засаг даргад хүргүүлж байна.

30. Зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ төсөвт батлагдсан нормын дагуу тооцогдсон зохиогчийн хяналтын зардлын дүнгээр захиалагчтай гэрээг байгуулан ажиллаж ирсэн байна. Зохиогч нь барилгын үе шат бүрд хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Тухайлбал:

- Баацагаан сумын ЭМТ-ийн өргөтгөлийн барилгад зохиогчийн хяналтыг 8 удаа
- Баян-Овоо сумын Цэцэрлэгийн барилгад зохиогчийн хяналтыг 3 удаа
- Баянговь сумын Дотуур байрны өргөтгөлд 2 удаа
- Эрдэнэмандал сургуулийн дотуур байрны барилгын угсралтын ажилд нийтдээ 7 удаагийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Б.3.2. Гүйцэтгэгч төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийг гаргаж ирүүлсэн тухай бүр системийн дээд байгууллагаас хянаж баталгаажуулж, санхүүжилтийн эрхийг нээж өгсөн байна.

31. 2020 оны Төсвийн тухай хуулиар аймгийн ТЕЗ-чид эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний тайлант онд 27206.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэхээр төлөвлөснөөс 97.0 хувь буюу 26348.1 сая төгрөгийн эрх нээж 26105.0 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлж зорилтыг 96 хувиар хангаж ажилласан байна.

БШУЯ-наас Баянхонгор аймгийн БСУГ-ын их засварын зураг төсвийн үнэ 16.8 сая, ЭМЯ-наас Богд сумын моргийн барилгын засвар 18.1 сая төгрөг нийт 26383.0 сая төгрөгийн санхүүжилтийн эрх нээсэн байна.

Хүснэгт 8 :ТЕЗ-аас санхүүжилтийн эрх нээсэн байдал

ТЕЗ-ын нэр	Мөнгөн дүн (сая. төг)
Байгаль орчин, аялал жуулчлалын хөрөнгө оруулалт	93.97
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам ХО-Их засвар	16.80
Боловсролын салбарын хөрөнгө оруулалт, их засвар	15,363.32
Засгийн газрын хэрэг эрхлэх газар ХО-ИЗ	535.15
Соёл, урлагийн хөрөнгө оруулалт, их засвар	6,171.08
Спортын салбарын ХО, ИЗ /2016-08-14/	2,000.00
Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар ХО-ИЗ	236.02
Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, их засвар	1,577.98
Эрчим хүчний хөрөнгө оруулалт, их засвар	388.73
<b>Нийт дүн</b>	<b>26,383.04</b>

Б.3.3. Хөрөнгө оруулалтын үйл явцад аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ болон Нийгмийн бодлогын хэлтсээс дотоод хяналтыг хэрэгжүүлсэн тайлан мэдээ байхгүй байна.



32. Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, ХОХБТХ-ээс УТХО-аар хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнд явцын хяналтыг хэрэгжүүлсэн боловч хэрэгжүүлсэн талаар ямар нэгэн тайлан, мэдээ байхгүй байна. /НБХ болон ХОХБТХ-ээс тодруулга авсан./

**Б.4 Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж, шинээр ашиглалтад орсон бүтээн байгуулалтын ажлууд нь үр ашгаа өгч, төрийн үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.**

Б.4.1. Засгийн газраас урьдчилгаа төлбөрийн баталгаагаар санхүүжилт олгоогүй ба ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан мөнгийг олгохдоо 1 төсөл арга хэмжээний 24,0 сая төгрөгийг ажлын гүйцэтгэлээс илүү олгосон байна.

33. Засгийн газрын 2019 оны 430 тоот тогтоолын дагуу өмнөх онд захиалагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан Галуут сумын Соёлын төвийн барилгын 209.6 сая, Баянцагаан сумын сургуулийн барилгын 401.1 сая, Жинст сумын дотуур байрны барилгын 113.6 сая, Богд сумын Соёлын төвийн барилгын 223.9 сая төгрөгийг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын даргын албан бичгээр эрх нээлгэж, ажлын гүйцэтгэлээр гүйцэтгэгчид тус тус олгосон. Тайлант онд аймгийн ТЕЗ-ийн барьцаа дансанд 3 төсөл арга хэмжээний дуусаагүй ажлын 243.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

- *Жинст сумын 150 хүүхдийн дотуур байрны барилгын гүйцэтгэгч “Жамъян пайтан” ХХК- ны 2019 оны үлдээгдэл санхүүжилт 113.6 сая төгрөгийг Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолыг үндэслэн Төрийн сангийн барьцаа хөрөнгийн 51350 тоот харилцах дансанд байршуулсан ба гүйцэтгэгч компанийн гаргасан гүйцэтгэлийг Барилга хөгжлийн төвөөс магадалшгүй ажлын зардал 24.0 сая төгрөгийг хасаж 89.6 сая төгрөг олгохоор хянасан байхад Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын газрын 2020.04.03-ны өдрийн 09/2019 тоот албан бичгээр 113.6 сая төгрөгөөр эрх нээсэн албан бичгээр эрх бүхий байгууллагын хянасан ажлын гүйцэтгэлээс 24.0 сая төгрөгийг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.*

Б.4.2. 2020 онд ашиглалтад орсон барилга, байгууламжаас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэр ирээгүйгээс 25572.9 сая төгрөгийн 16 төсөл арга хэмжээг хөрөнгөд бүртгээгүй, 2020 онд хэрэгжсэн 25 төсөл арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна.

34. Баянхонгор аймагт 2020 оны УТХО-аар хэрэгжүүлж, хэрэгжилт нь дууссан 30465.9 сая төгрөгийн 25 төсөл арга хэмжээнээс 4892.9 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээг хөрөнгөд бүртгэсэн ба үлдсэн 25572.9 сая төгрөгийн 16 төсөл арга хэмжээг хөрөнгөд бүртгээгүй байна.

**Аудитын илрүүлэлт:**


- *2020 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020.11.24-ний өдрийн 577 дугаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Баянхонгор аймгийн өмчид бүртгэж авах үл хөдлөх хөрөнгийн жагсаалт” тогтоолыг үндэслэн Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 35 болон 121 дугаар тогтоолоор 11 төсөл арга хэмжээний 4892.9 сая төгрөгийн хөрөнгө орлого авах шийдвэр гарсан байхад*



Хүүхдийн “Тэмүүжин” театрын их засварын ажил 162.1 сая төгрөгийг хөрөнгөд орлогоор бүртгээгүй байна.

Иймд Хүүхдийн “Тэмүүжин” театрын их засварын ажил 162.1 сая төгрөгийн хөрөнгийн орлого авах албан шаардлагыг хүргүүлж байна

35. УТХО-аар 2020 онд 25 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. Үүнээс хэрэгжсэн төсөл арга хэмжээг салбараар нь харуулбал:



Соёлын салбарт шинээр 5 соёлын төв ашиглалтад, 1 соёлын төвийн барилга, Хүүхдийн Тэмүүжин театрт их засвар хийснээр олон нийтэд соёлын иж бүрэн үйлчилгээг иргэдэд хүргэж ая тухтай орчин бүрдсэн боловч тайланд онд цар төсөл арга хэмжээ алтай холбоотойгоор үйлчилгээ явуулах боломжгүй байгаа тул хөрөнгө оруулалтын үр өгөөжийн тооцох боломжгүй байна.

- Боловсролын салбарт аймгийн төвд Номун далай ахлах сургууль, 3 суманд ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны барилгыг шинээр барьж ашиглалтад хүлээлгэн өгсөн, сургуулийн барилгын болон дотуур байрыг засварласнаар нийт 3342 хүүхдийн сурах орчин сайжирч, 2 цэцэрлэгийн барилгад өргөтгөл, их засвар хийгдсэнээр 500 хүүхэд ая тухтай орчинд сурч хүмүүжих бололцоотой болсны 310 хүүхэд шинээр сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломж нэмэгджээ.

- Эрүүл мэндийн салбарт 3 суманд Эрүүл мэндийн төвийн өргөтгөл хийж, 2 сумын эрүүл мэндийн төвд их засвар хийснээр орны тоо 33-аар нэмэгдэж, үйлчилгээний хүртээмж сайжирсан. Амбулаторийн үзлэгээр жилд давхардсан тоогоор 29234 иргэн үйлчлүүлж, 1456 иргэн хэвтэн эмчлүүлэх нөхцөл бололцоогоор хангагдсан байна.

- Баянговь сумын ЗДТГ 2020 онд ашиглалтад орсон бөгөөд хөрөнгө оруулалтын үр дүнд төрийн албан хаагчид тав тухтай орчинд ажиллах, иргэд төрийн үйлчилгээг тохилог тухтай орчинд авах нөхцөл бүрдсэн байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

- Монгол улсын 2020 оны Төсвийн тухай хуульд “Сургуулийн дотуур байрны их засвар Баянхонгор Баянговь” нэрээр батлагдсан байхад Баянговь сумын сургуулийн дотуур байрны гал тогооны өргөтгөлийн ажил хийгдсэн нь дотуур байрны хүүхдүүдийн аятай, тухтай эрүүл, аюулгүй орчин бий болгох зорилтот түвшнийг хангаагүй байна.

- Монгол улсын 2020 оны Төсвийн тухай хуульд “Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар Баян-Өндөр сум” нэрээр батлагдсан байхад Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгыг барьсан байна.

Иймд Монгол улсын Төсвийн тухай хуульд заасан их засварын ажилд батлагдсан төсөл арга хэмжээг өргөтгөл болгон нэршил, зориулалтыг өөрчилж хэрэгжүүлэхийг таслан зогсоож Сангийн сайдын 2019 оны 282 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9.28 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

#### **Аудитын илрүүлэлт:**

- Баянхонгор аймгийн Хот төлөвлөлтийн төлөвлөгөөний дагуу шинэ суурьшлын бүсэд баригдаж 2019 онд ашиглалтад орсон 14 ортой эмнэлгийн барилгын инженерийн гадна шугам сүлжээний ажил хийгдээгүйгээс тус барилгыг ашиглаж эхлээгүй байна.



- 2020 оны 05 дугаар сард Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх “Хүмүүнлэгийн ордон” -д үйл ажиллагаа явуулах хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх төрийн болон төрийн бус 10 байгууллагыг ажиллуулахаар шийдвэрлэсэн. Баянхонгор аймгийн Засаг даргын 2020.12.25-ны өдрийн А/842 тоот захирамжаар Хүмүүнлэгийн ордныг зориулалтын дагуу Төрийн болон Төрийн бус байгууллагуудад түрээсийн болон ашиглалтын гэрээ байгуулан ажиллахыг Аймгийн ЗДТГ-ын даргад үүрэг болгон шийдвэрлэсний дагуу ашиглагч байгууллагуудтай ашиглалтын болон түрээсийн гэрээ байгуулах гэрээ байгуулсан боловч тухайн барилгын ихэнх /дөрөвний нэг/ хэсгийг ашигладаг “Улаан загалмайн хороо” ашиглалтын гэрээг байгуулаагүй байна.

Цаашид төсвөөс гарах ашиглалтын зардлын тодорхой хувийг нөхөх хэмжээнд үйл ажиллагааг явуулах боломжийг судалж төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн журам боловсруулж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Өмнөх оны аудитаар 132.5 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 950.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 7556.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 7 заалт бүхий зөвлөмж өгснийг төлбөрийн акт, албан шаардлагыг барагдуулж, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт . Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт

№	Өгсөн зөвлөмж	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	
<b>Нэг. Аймгийн Засаг дарга Г.Батжаргал танаа</b>			
1	Зураг, төсвийн ажлыг хүлээн авахдаа орчны стандартын шаардлага хангасан эсэхийг хянаж, гадна тохижилт, хашаа хайс бүхий ирж бүрэн, хэрэгцээ шаардлага бүрэн хангасан зураг төсвийг хүлээн авч байх.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Цаашид анхаарч ажиллаж байна.
		Аудитаар тооцсон биелэлт	2020 онд шинээр баригдаж байгаа Баацагаан сумын ЗДТГ, Баянбулаг сумын дотуур байрны барилга, Заг сумын сургуулийн барилга, Баян-Овоо сумын цэцэрлэгийн барилгын зураг төсөвт гадна талбайн тохижилт, зүлэгжүүлэлтийн ажил суугдсан байна. <b>Биелэлт 80%</b>
2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтад батлуулах төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг урьдчилан хийлгэж, магадлалаар баталгаажуулсны дараа төсөвт оруулан батлуулж, Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг хангаж ажиллах	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр 27 төсөл арга хэмжээ батлагдсан бөгөөд бүх ажлын зураг төсвийг магадлалаар оруулж баталгаажуулсан.
		Аудитаар тооцсон биелэлт	2020 онд шинээр хэрэгжих 17 төсөл арга хэмжээний 13 төсөл арга хэмжээний зураг төсвийг Төсвийн тухай хуульд батлагдсанаас хойш магадлалаар оруулж баталгаажуулсан байна.. <b>Биелэлт 76%</b>
3	Төсөл, арга хэмжээний эрх шилжиж ирсэн шийдвэр ирсэн дариуд нь үнэлгээний хороог байгуулан, худалдан авах ажиллагааг богино хугацаанд зохион байгуулж ажиллах.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудыг Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 21-р тогтоолын 1-р хавсралтаар эрх шилжиж ирсэн ба ЗДТГ-ын даргын 202.02.20-ны өдрийн тушаалаар бүх ажлын үнэлгээний хороог байгуулж ажилласан.
		Аудитаар тооцсон биелэлт	Бүрэн хэрэгжсэн. <b>Биелэлт 100%</b>
4	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу бодитой төлөвлөж, дотоод хяналтын нэгжээр хянуулан, өөрчлөлт орсон тохиолдолд "Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	ОНӨГ нь тухайн онд батлагдсан төвийн тухай хууль болон захирамж тушаал гэх зэрэг эрх зүйн баримт материалыг тодорхой тусган баримталж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж батлуулдаг ба батлагдсанаас хойш 3 хоногийн дотор Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим систем болох tender.gov.mn-д оруулж төсвийн асуудал эрхэлсэн төрийн



	төлөвлөх тайлагнах журам"-ын 2.9 дэх заалтын дагуу өөрчлөлтийг тайлагнахдаа тодорхой тусгаж ажиллах.		захиргааны төв байгууллагаар батлуулж хянуулж ажилладаг болсон
		Аудитаар тооцсон биелэлт	Бүрэн хэрэгжсэн. <b>Биелэлт 100%</b>
5	Зохиогчийн хяналт тавьсан тухай бүрд нь хяналт хийсэн тайланг авч, гарч буй зөрчил дутагдлыг арилгах ажлыг шуурхай зохион байгуулж, зохиогчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэж ажиллах.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хүсэлтийг илгээхдээ Зохиогчийн хяналтын тайлан болон Захиалагчийн хяналтын тайланг тухай бүр нь авч хавсарган холбогдох яамнуудад хүргүүлэн ажиллаж байна.
		Аудитаар тооцсон биелэлт	Зохиогчийн хяналтын хяналтын тайланг тухай бүр нь авч ажлын баримтад хавсаргасан байна. <b>Биелэлт 90%</b>
6	Гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа гүйцэтгэгч нарт санхүүжилт олгохдоо ажлын гүйцэтгэлийг хянаж, гүйцэтгэлд гарын үсэг зурж байгаа албан тушаалтнуудын хариуцлагыг сайжруулан, гүйцэтгээгүй ажилд санхүүжилт өгдөг байдлыг бүрэн зогсоох.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа гүйцэтгэгч нарт санхүүжилт олгохдоо ажлын гүйцэтгэлийн фото зураг болон гүйцэтгэл 2-той тулган хянаж, мөн Зохиогчийн хяналтын тайлан болон Захиалагчийн хяналтын тайланг тус тус хавсаргаж, хянаж гүйцэтгэлийг олгож байна.
		Аудитаар тооцсон биелэлт	Тайланд онд 2 төсөл арга хэмжээнд гүйцэтгээгүй ажилд санхүүжилт олгосон зөрчилд давтагдан гарсан байна.. <b>Биелэлт 60%</b>
7	Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гэрээнд заасан чанарын баталгааны барьцааг бүрэн төвлөрүүлж байх.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Ажлаа 100.0 хувь дууссан комиссын акт гарсан тохиолдолд хамгийн сүүлийн гүйцэтгэлээс Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу Чанарын баталгаа 5 хувийг суутган Төрийн сангийн барьцаа хяналтын 100030051350 тоот дансанд 1 жилийн хугацаатай төвлөрүүлэн ажиллаж байна.
		Аудитаар тооцсон биелэлт	Ашиглалтад орсон 14 объектын 1566.7 сая төгрөгийн баталгаа байршуулснаас 1 ТАХ-ны 20.0 сая төгрөгийг гүйцэтгэгчид буцаан олгосон байна. <b>Биелэлт 95%</b>
			<b>БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ 85%</b>

Аудитаар нийт 806.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 27.8 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 382.8 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 395.5 сая төгрөгийн 7 зөвлөмж, хүргүүлэн ажиллав.



## АУДИТЫН ДҮГНЭЛТ.

Гүйцэтгэлийн аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч УТХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг салбарын бодлого, орон нутгийн хэрэгцээ шаардлагын үндэслэн эрэмбэлж, холбогдох яамдад хүргүүлсэн байна.
2. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаартай нийцэж байна.
3. Төсвийн тухай хуулийн жагсаалтад батлагдан Баянхонгор аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсэн 40 төсөл арга хэмжээнээс 8395,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажлын даалгавар, магадлалын дүгнэлт нь 2020 оны Төсвийн тухай хууль батлагдсанаас хойш хийгдсэн нь Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 3.2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй, зөрчил дутагдал давтагдан гарч байна.
4. ГХБХБГ нь УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний баримт бичгийн иж бүрдлийг Барилгын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь заалтын дагуу бүрэн бүрдүүлээгүй байна.
5. Барилга, байгууламжийн зураг, төсөл зохиох ажлын даалгаврыг салбарын бодлого, хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлага, геологийн дүгнэлт, техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл зэрэгт үндэслэж, боловсруулж байгаа боловч зураг төсвийн үнэ харилцан адилгүй, зарим зураг төсвийн үнэ нийт төсөвт өртгийн 5 -аас дээш хувийг эзэлж байна.
6. Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан зураг төсөвт тавих шаардлагыг хангаагүйгээс тайлант онд 4 төсөл арга хэмжээний төсөвт өртөг 5018,3 сая төгрөгөөр нэмэгдсэн, 4 ажилд 613,6 сая төгрөгийн нэмэлт ажил хийгдсэн зэрэг нь гадна инженерийн шугам сүлжээний ажил, орчны стандартыг хангахуйц, зайлшгүй тусгах шаардлагатай гадна тохижилт, гэрэлтүүлэг, зүлэгжүүлэлтийн ажлыг оруулаагүй зураг төсвийг Барилгын хөгжлийн төв магадлалын дүгнэлт гарган баталгаажуулж дээрх ажлуудад дахин зураг төсөв хийж зураг төсвийн үнэ гарч байгаа нь төсөвт хүндрэл учруулж, ажлын явц удаашрах, хугацаандаа ашиглалтад орохгүй байх үндсэн нөхцөл болж байна.
7. Захиалагч, гүйцэтгэгч нь Сангийн сайдын 2019 оны 282 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9.28 дахь заалтыг зөрчиж Төсвийн тухай хуулиар батлагдсан төсөл арга хэмжээний нэрийг өөрчилж Баянговь сумын сургуулийн дотуур байр, Баян-Өндөр сумын ЭМТ-ийн их засварын ажилд батлагдсан төсвөөр өргөтгөлийн барилга барьсан бөгөөд цаашид төсвийн тооцоолоогүй урсгал зардал нэмэгдэж хүндрэл учруулж байна.



8. Тайлант онд ашиглалтад орсон 26 төсөл арга хэмжээний чанар байдлын талаар ашиглагч байгууллагаас ирүүлсэн саналаас үзэхэд 11 төсөл арга хэмжээ нь ашиглалтын явцад чанарын шаардлага хангахгүй, дахин засварлуулах шаардлагатай байна.
9. Захиалагч, зохиогчийн зүгээс төсөл арга хэмжээний үе шатны ажлын хяналтыг хэрэгжүүлж, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулан ажиллаж байгаа боловч Баянговь сумын Нутгийн удирдлагын ордны барилгын 70.7 сая, Жинст сумын Соёлын төвийн барилгын 150.0 сая төгрөгийн ажлууд бүрэн хийгдээгүй байхад гүйцэтгэлийг баталгаажуулж санхүүжилтийг олгосон ба улсын комисс дүгнэлт гарган гарын үсэг зурж ашиглалтад хүлээн авсан байна.
10. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж, шинээр ашиглалтад орсон бүтээн байгуулалтын ажлууд нь үр ашгаа өгч, төрийн үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

**ҮАГ-т хүргүүлэх санал:**

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Төсөл, арга хэмжээний зураг төсвийн үнийг БХБС-ын 2012 оны 06 дугаар сарын 13-ны 182 тоот тушаалаар баталсан “Дүрэм батлах тухай”, 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 108 дугаар тушаалаар “Барилгын дүрэм шинэчлэн батлах тухай” -аар батлагдсан жишиг үнийг баримталж байгаа гэх боловч аудитын явцад хийсэн судалгаанаас үзэхэд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний зураг төсвийн үнэ харилцан адилгүй, дүрэмд баримтлах жишиг үнэ тодорхой бус, тооцоход хүндрэлтэй байна.

Иймд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний зураг төсвийн үнийг мэргэжлийн шинжээчээр хянуулж дүгнэлт гаргуулан орон нутгийн байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх шаардлагатай байна.

Хоёр. УТХО-аар хэрэгжих төсөл арга хэмжээний зураг төсвийг төсөл арга хэмжээний батлагдсан төсөвт багтаан орчны стандартыг хангасан гадна тохижилт, зам, инженерийн шугам сүлжээний ажлыг орхилдуулан магадлалаар баталгаажуулж байгаагаас төсөв нэмж батлагдаж, нэмэгдсэн төсөвт дахин зураг, төсөв зохиож, зураг, төсвийн үнэ гарч байгаа нь төсөвт хүндрэл учруулж байна.

Иймд зураг төсөв зохиох, магадлалаар баталгаажуулахдаа тухайн төсөл арга хэмжээний зураг төсвийг Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан тавигдах шаардлагыг бүрэн хангуулж иж бүрэн боловсруулж баталгаажуулах албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлэх саналтай байна. */Илэрсэн зөрчлийг аудитын тайлангийн А.2.3-аас үзнэ үү/*

**ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:**

1. Төсвийн ерөнхийлөн захирагчдад зураг төсөв нь Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан, иж бүрэн хийгдэж магадлалаар баталгаажуулсан төсөл арга хэмжээний саналыг хүргүүлж байх,
2. Барилга, байгууламжийн ашиглалтад хүлээн авах улсын комисс нь ажлыг хүлээж авахдаа магадлалаар баталгаажсан, зураг төсөвт тусгагдаагүй, эх үүсвэр шийдэгдээгүй нэмэлт ажил гүйцэтгэхийг шаардаж төсөвт хүндрэл учруулж байгааг зогсоох
3. Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж, төсөл, арга хэмжээг батлагдсан нэрээр нь хэрэгжүүлж зорилтот түвшнийг хангаж ажиллах.
4. Захиалагч, зохиогчийн хяналт хийсэн тайланг тухай бүр авч, гэрээг объект тус бүрээр дүгнэж, хэрэгжилтийг тооцож, төлбөр тооцоог хийж байх
5. УТХО-аар хэрэгжүүлж 2020 онд ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн дутуу болон чанаргүй гүйцэтгэсэн ажилд Мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
6. Хүмүүнлэгийн ордны барилгын ашиглалтыг сайжруулах, төсвөөс хөрөнгө гаргахгүйгээр ашиглалтын зардлаа нөхөх хэмжээнд үйл ажиллагааг явуулах боломжийг судалж төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн журам боловсруулж ажиллах.
7. Баянговь сумын нутгийн удирдлагын ордон, Жинст сумын Соёлын төвийн гүйцэтгэгч нарт хийгдээгүй ажлын гүйцэтгэлийг хянаж дүгнэлт гарган баталгаажуулж барилгыг хүлээн авсан комиссын буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцох.

Зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил, түүний хэрэгжилт, үр дүнг 2021 оны 10 дугаар сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

6417143544  
БНДА0067 9007423



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Вэбсайт: www.bayankhongor.gov.mn  
Утас: 7044-5018, Факс: 7044-3206

2021.04.29 № 14/295

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Санал хүргүүлэх тухай

Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Баянговь сумын Нутгийн удирдлагын ордоны барилгын нэмэлт ажлыг Улсын төсвийн 2020.08.28-ны өдрийн төсвийн тодотголоос өмнө санхүүжүүлсэн бөгөөд санхүүжүүлсэний дараа нийт төсөвт өртөгийг буруулж баталсан байна.

Дээрхи аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актуудыг холбогдох газруудад хүргүүлж зөрчлийг заасан хугацаанд бүрэн барагдуулж, цаашид алдааг давтан гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах болно.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэлийн төсөл

Аудитын нэр: Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг  
 Аудитын код:БНА-2021/06-04-ШТА-ГА  
 2021.04.30

Баянхонгор

№	Аудитын чиглэл	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан байгууллага, албан тушаалтны		
				Нэр	Огноо	Дугаар	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр
А	1	3	4	5	6	7	8	9	
1	А.2 Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй байна уу	Аудитаар 2020 онд ашиглалтад хүлээн авсан 14 барилга байгууламжийн баримт бичгийн иж бүрдлийг аймгийн ГХБХБГ-ын ирүүлсэн цахим файлаас тулган шалгахад 378 баримт бичиг байхаас 159 буюу 42.1 хувь байгаа нь баримт бичгийн иж бүрдэл хангалтгүй байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	2021.04.30	120	Баянхонгор аймгийн ГХБХБГ	Дарга	Д.Алтангэрэл
2		Шинэжинст сумын Соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч "Стандарт тоосго" ХХК-д техник хяналтын зардал 846,7 мянган, зохиогчийн хяналтын зардал 423,3 мянган, нийт 1270,0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн	1.3	Төлбөрийн акт	2021.04.30	117	Баянхонгор аймгийн ХОХБТХ	Даргыг түр орлон гүйцэтгэгч	Т.Хишигбаатар
3		Баян-Овоо сумын 240 хүүхдийн сургуулийн барилгын гүйцэтгэгч "Зүүн шанд" ХХК-д техник хяналтын зардал 167,7 мянган, зохиогчийн хяналтын зардлын 461,3 мянган, нийт 629,0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн	0.6	Төлбөрийн акт	2021.04.30	118	Баянхонгор аймгийн ХОХБТХ	Даргыг түр орлон гүйцэтгэгч	Т.Хишигбаатар
4		Жинст сумын 240 хүүхдийн Сургуулийн барилгын зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн "Цэсда" ХХК-д хяналтын зардлын 1909,8 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн	1.9	Төлбөрийн акт	2021.04.30	119	Баянхонгор аймгийн ХБХОТХ	Даргыг түр орлон гүйцэтгэгч	Т.Хишигбаатар
5	А.2 Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнтэй байна уу	Жинст сумын 150 хүүхдийн дотуур байрны барилгын гүйцэтгэгч "Жамъян пайтан" ХХК-нийн 2019 онд барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан гүйцэтгээгүй ажлын санхүүжилтийн 113639,8 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэлийг Барилга хөгжлийн төвөөс хянахдаа магадлалгүй ажлын зардал 24029,4 мянган төгрөгийг хасаж хянасан байхад гүйцэтгэгчид олгосон	24.0	Төлбөрийн акт	2021.04.30	120	Баянхонгор аймгийн ХБХОТХ	Даргыг түр орлон гүйцэтгэгч	Т.Хишигбаатар
6		УТХО-аар 2020 онд эрх шилжсэн 40 ТАХ-нээс 8395.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ТАХ-ний зураг, төсөв боловсруулах ажлын даалгавар, зураг төсвийн магадлалын ерөнхий дүгнэлт нь 2020 оны Төсвийн тухай хууль батлагдсанаас хойш баталгаажсан байна.	-	Зөвлөмж хүргүүлэх			Баянхонгор аймгийн Засаг дарга	Засаг дарга	Д.Мөнхсайхан
7	Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулсан уу?	Аудитаар 2020 онд ашиглалтад хүлээн авсан 26 төсөл арга хэмжээний чанар байдлыг ашиглагч байгууллагаас ирүүлсэн саналыг нэгтгэн үзэхэд 11 төсөл арга хэмжээ нь ашиглалтын явцад чанарын шаардлага хангахгүй байна.	-	Зөвлөмж хүргүүлэх			Баянхонгор аймгийн Засаг дарга	Засаг дарга	Д.Мөнхсайхан
8		Монгол улсын 2020 оны Төсвийн тухай хуульд их засвар нэрээр батлагдсан Баянговь сумын дотуур байрны их засвар, Баян-Өндөр сумын ЭМТ-ийн их засварын төсвөөр өргөтгөлийн барилга барьсан	-	Зөвлөмж хүргүүлэх			Баянхонгор аймгийн ХБХОТХ	Даргыг түр орлон гүйцэтгэгч	Т.Хишигбаатар

№	Аудитын чиглэл	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан байгууллага, албан тушаалтны		
				Нэр	Огноо	Дугаар	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	3	4	5	6	7	8	9	
9	A.2.3.Барилга, байгууламжийн зураг төслийг холбогдох хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм, төсвийн үнэ бүрдэл олон төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар баталгаажуулсан уу?	Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комисс нь ажлыг хүлээн авахдаа зураг төсөвт байхгүй гадна орчны тохижилт, хайсжуулалт, гэрэлтүүлгийн ажил хийх зөвлөмж өгч түүний дагуу 2020 онд аймгийн Засаг даргын захирамжаар 3 төсөл, арга хэмжээнд 395.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь төсөвт хүндрэл учруулж байна.	395.5	Зөвлөмж хүргүүлэх			Баянхонгор аймгийн Засаг дарга	Засаг дарга	Д.Мөнхсайхан
10	B.3.1. ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтын үр ашигтай тогтолцоог бүрдүүлж, үе шатны хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж, баталгаажуулсан уу?	Баянговь сумын Нутгийн захиргааны ордны барилгын 70.7 сая төгрөгийн нэмэлт ажил, Жинст сумын 240 суудалтай Соёлын төвийн барилгын 150.0 сая төгрөгийн гүйцэтгээгүй ажлыг бүрэн гүйцэтгэсэн дүгнэлт гаргаж хүлээн авсан.	-	Зөвлөмж хүргүүлэх			Баянхонгор аймгийн Засаг дарга	Засаг дарга	Д.Мөнхсайхан
11	B.3. ТАХ-ний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?	Жинст сумын 240 суудалтай Соёлын төвийн барилгын нэмэлт ажлын гүйцэтгэгч "Рино Инженеринг" ХХК нь "Гадна хашаа, тохижилт, гэрэлтүүлэг" ийн ажлуудыг гүйцэтгэснээр ажлын гүйцэтгэл 150,0 сая төгрөгийн санхүүжилт авсан атлаа ажлыг гүйцэтгээгүй байна.	150.0	Албан шаардлага хүргүүлэх	2021.04.30	121	Баянхонгор аймгийн Засаг дарга	Засаг дарга	Д.Мөнхсайхан
12		Баянговь сумын Нутгийн захиргааны ордны барилгын ажлын гүйцэтгэгч "Очир заан" ХХК нь 70,7 сая төгрөгийн "Гадна хашаа, тохижилт"-ын нэмэлт ажлыг бүрэн гүйцэтгэснээр гүйцэтгэл гарган баталгаажуулж санхүүжилтийг авсан	70.7	Албан шаардлага хүргүүлэх	2021.04.30	122	Баянхонгор аймгийн Засаг дарга	Засаг дарга	Д.Мөнхсайхан
13	B.3.3. Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засгийн газрын болон ТЕЗ-дын дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, ХОХБТХ-ээс УТХО-аар хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээнд явцын хяналтыг хэрэгжүүлсэн боловч хэрэгжүүлсэн талаар ямар нэгэн тайлан, мэдээ байхгүй байна	-	Зөвлөмж хүргүүлэх			Баянхонгор аймгийн Засаг дарга	Засаг дарга	Д.Мөнхсайхан
14	B.4.2. 2020 онд ашиглалтад орсон барилга, байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгаж, бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна уу?	УТХО-аар хэрэгжүүлж 2020 онд ашиглалтад хүлээн авсан 162163,1 мянган төгрөгийн "Тэмүжин театрын их засварын ажил"-ыг орлогод аваагүй, бүртгэлд тусгаагүй	162.1	Албан шаардлага хүргүүлэх	2021.04.30	123	Баянхонгор аймгийн Хүүхдийн тэмүүжин театр	Дарга	Б.Ганчимэг
15	B.4.2. 2020 онд ашиглалтад орсон барилга, байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгаж, бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна уу?	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх "Хүмүүнлэгийн ордон" д үйл ажиллагаа явуулж буй "Улаан загалмайн хороо" ашиглалтын гэрээг байгуулаагүй байна.	-	Зөвлөмж хүргүүлэх			Баянхонгор аймгийн Засаг дарга	Засаг дарга	Д.Мөнхсайхан
		ЗӨРЧЛИЙН НИЙТ ДҮН	806.1						
		Үүнээс: Төлбөрийн актны дүн	27.8						
		Албан шаардлагын дүн	382.8						
		Зөвлөмжийн дүн	395.5						

АХЛАХ АУДИТО  
ГЭРЭЭТ АУДИТОР

БЭЛТГЭСЭН:  
М.АЛТАНТУЯА  
Д.ЦЭЦЭГМАА

ХЯНАСАН:  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР
